



Иргэний үнэмлэх ямар ач холбогдолтой баримт бичиг вэ?

Монгол Улсын иргэний үнэмлэх нь Монгол Улсын иргэнийг гэрчлэх бичиг баримт болдог богоод тvvнийг авах хvртэл 16-аас доош насны иргэний хувьд регистрийн дугаартай торсний гэрчилгээ байна.

Иргэний үнэмлэхэд ямар мэдээллvүд ил бичигддэг вэ?

Улсын бүртгэлийн еронхий хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 396 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын иргэний үнэмлэхийн дvрэм”-д зааснаар иргэний үнэмлэх дээр иргэний цээж зураг, овог, эцэг, /эх/-ийн нэр, оорийн нэр, торсон он, сар, одор, регистрийн дугаар, хvйс, олгосон байгууллагын нэр, олгосон он, сар, одор, хvчинтэй хугацаа, иргэний оршин суугаа газрын хаяг зэрэг мэдээлэл ил харагдах байдлаар бичигддэг.

16 нас хvрч анх удаа иргэний үнэмлэх авах иргэн ямар бичиг баримт бүрдvүлж, хаана хандах вэ?

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зvйлийн 16.5-д зааснаар Монгол Улсын иргэн 16 нас хvрсэн одроос хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэх авах vүрэгтэй. Бvртгvүлэхдээ торсний гэрчилгээ, эцэг, эх, эсхvл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэхийг бүрдvүлж, оорийн биеэр бүртгvүлдэг. Учир нь иргэний

үнэмлэх анх удаа авч байгаа иргэн биеийн давхцахгүй огодлийн бүртгэл /гарын хурууны хээ/-д бүртгүүлдэг тул зайлшгүй оорийн биеэр бүртгүүлэх ёстой байдаг. Харин Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д заасны дагуу иргэний үнэмлэхийн бүртгэлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэдэг тул 16 насанд хүрч иргэний үнэмлэхээ анх удаа авах, 25, 45 насанд сольж авах, дахин авах тохиолдолд иргэн улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь аль ч газар, хэлтэс, тасагт бүртгүүлж, иргэний үнэмлэхээ захиалах боломжтой.

Иргэний үнэмлэхийг ямар тохиолдолд сольж олгох вэ?

Иргэний үнэмлэхийг 25, 45 нас хүрсэн иргэнд тухайн насанд хүрсэн одроос хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэхээ сольж олгохын зэрэгцээ овог, эцэг /эх/-ийн нэр, оорийн нэр, торсон он, сар, одор, регистрийн дугаар, хүйс оорчлогдсон, эсхүл дүр торхийн оорчлолт орсон бол сольж олгох зохицуулалттай.

Иргэний үнэмлэхийг хугацаанд нь сольж аваагүй бол хариуцлага хүлээх үү?

Иргэний үнэмлэхээ хуульд заасан хугацаанд сольж аваагүй бол Зорчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулдаг. Зорчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний тогроогоор торгоно” гэж заасан бөгөөд зорчлийг улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шийдвэрлэж, шийтгэл оногдуулахаар заасан.

Иргэний үнэмлэхийг гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн болон хүчинтэй байдлыг алдагдуулсан бол иргэний үнэмлэхээ яаж дахин авах вэ?

Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу иргэний үнэмлэхийн бүртгэлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэдэг тул гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн болон хүчинтэй байдлыг алдагдуулсан дахин авах тохиолдолд иргэн улсын

бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь аль ч газар, хэлтэс, тасагт бүртгүүлж, иргэний үнэмлэхээ захиалах боломжтой.

Иргэн иргэний үнэмлэхээ гэсэн, үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн иргэний биечлэн гаргасан оргодол, эсхүл 18 насанд хүрээгүй хvний иргэний үнэмлэхийг эцэг /эх/, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хvхдийг асран хvмvвжvвлэх байгууллагын толоологчийн оргодол, хяналтын улсын байцаагчийн шийдвэрт vндэслэн иргэний үнэмлэх дахин олгоно.

2018 оны 11 дvгээр сарын 1-ний одроос эхлэн улсын бүртгэлийн багц хууль хэрэгжиж эхэлсэн. Улсын бүртгэлийн еронхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулиар иргэний улсын бүртгэлийг цахимаар хотлох боломжийг бүрдvүлсэн. Иймээс иргэний үнэмлэхээ гэсэн, үрэгдvүлсэн тохиолдолд www.burtgel.mn цахим хуудсаар захиалах боломжтой болсон. Хэрэв иргэн цахим гарын үсэгтэй бол цахим гарын үсгээр, цахим гарын үсэггүй бол системээс нэг удаа олгосон кодоор нэвтэрч иргэний үнэмлэхээ захиалах болон иргэний үнэмлэхийн лавлагаа авах боломжтой.

Харин иргэний үнэмлэх анх удаа авах, 25, 45 насанд сольж авахад биеийн давхцахгүй огодлийн бүртгэл /гарын хурууны хээ/-д бүртгvүлэх тул иргэн оорийн биеэр хандах ёстой байдаг.

Иргэний үнэмлэхийг гэсэн, үрэгдvүлсэн, гэмтээсэн болон хvчинтэй байдлыг алдагдуулсан бол хариуцлага хvлээлгэх vү?

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 396 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын иргэний үнэмлэхийн дvрэм”-д зааснаар иргэн иргэний үнэмлэхийн цэвэр гамтай эзэмших, хадгалах, оршин суугаа газрын хаягаа оорчлох тохиолдолд харьяалагдах сум, хорооны улсын бүртгэгчид хандан шилжилт ходолгооний бүртгэлд бүртгvүлж, иргэний үнэмлэхийн санах ой (чип)-д байнга оршин суух газрын хаягийн мэдээллээ тэмдэглvүлэх vүрэгтэй.

Иргэний үнэмлэхийг гэсэн, үрэгдvүлсэн бол Зорчлийн тухай хуулийн 15.24 дvгээр зvйлийн 4 дэх хэсэгт “Иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зорчсон бол хvнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний тогрогоор, хуулийн этгээдийг гурван зуун

нэгжтэй тэнцэх хэмжээний тогрогоор торгоно” гэж заасны дагуу хяналтын улсын байцаагч зорчлийг шийдвэрлэж, шийтгэл оногдуулна.

Тvvнчлэн хууль, дvрэмд зааснаар иргэн иргэний үнэмлэхийг гэмтээх, бусдад барьцаалуулах, хууль тогтоомжид зааснаас бусад этгээд бусдын үнэмлэхийг товлорvvлэн хадгалах барьцаалж авах, гэмтээх, ашиглахыг хориглосон байдаг.

Харин иргэний үнэмлэхийг барьцаалсан, барьцаалуулсан, зориуд гэмтээсэн бол хvнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний тогрогоор, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний тогрогоор торгоно.

Иргэний үнэмлэх шинээр авах болон дахин захиалахад хэдэн төгрөгний хураамж, вйлчилгээний хөлс төлөх вэ?

Тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу иргэний үнэмлэх авахад 18,300 тогрог толно.

Хэрэв иргэн улсын бүртгэлд бүртгvvлэх тогтоосон хугацааг зорчсон, иргэний үнэмлэхээ гээсэн, vрэгдvvлсэн, гэмтээсэн бол Зорчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хвлээхээр байгаа.

Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэний хувьд иргэний үнэмлэхээ захиалах боломжтой юу?

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэний хувьд Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат толоологчийн газар, Консулын газарт хандан иргэний үнэмлэхээ захиалан авах боломжтой.

Иргэний үнэмлэх хэд хоногийн дотор олгох вэ?

Иргэний үнэмлэхийг 16 насанд хvрч анх удаа авах, 25, 45 насанд сольж авахад нийслэлд ажлын 5, суманд ажлын 15, Дипломат толоологчийн газар ажлын 45 одрийн дотор олгоно. Харин иргэний үнэмлэхийг дахин авах тохиолдолд нийслэлд ажлын 3, суманд ажлын 10, Дипломат толоологчийн газар ажлын 30 одрийн дотор олгоно.

Улсын бүртгэлийн ерөнхий газар